



TAVAN BOGD CAPITAL


БАНКНЫ САЛБАРЫН ТОЙМ

2022 оны 12 сар

2023.01.25

БАНКНЫ САЛБАРЫН ӨСӨЛТ


- » Банкны салбарын нийт активын сүүлийн 10 жилийн дундаж өсөлт 17.07 хувь байна.
- » Хэвийн зээл 18.71 их наяд буюу нийт активын 40.68 хувийг эзлэж байна. Хэвийн зээлийн дүн өмнөх сартай харьцуулахад 0.51 хувиар өссөн бол өмнөх онтой харьцуулахад 6.68 хувиар өссөн байна.
- » Аж ахуйн нэгж, иргэдийн харилцах өмнөх сартай харьцуулахад 16.41 хувиар өссөн, өмнөх онтой харьцуулахад 49.47 хувиар өссөн байна. Харин нийт хадгаламж өмнөх сартай харьцуулахад 3.04 хувиар өссөн, өмнөх онтой харьцуулахад -9.27 хувиар буурсан байна.
- » 2022 он гарснаар бодлогын хүүг 6 удаа нэмж, 13%-д хүргэсэн нь хүүгийн түвшинг цаашид үргэлжүүлэн өсгөх нь тодорхой боллоо.



Эх сурвалж: Монгол банк – Банкуудын нэгдсэн тайлан

ЗЭЭЛИЙН ЧАНАР

- » 2022 оны 12 сарын 31-ны өдрийн байдлаар зээлийн үлдэгдэл 22.0 их наяд хүрч өмнөх сартай харьцуулахад -1.96 хувиар буурсан бол өмнөх онтой харьцуулахад 6.49 хувиар өссөн байна. Нийт зээлийн үлдэгдэлийн 21.6%-ийг бөөний болон жижиглэн худалда, машин, мотоциклийн засвар, үйлчилгээний салбарын, 15.5%-ийг үл хөдлөх хөрөнгийн салбарын зээлийн үлдэгдэл тус тус эзлэж байна.
- » Хэвийн зээл 18.71 их наяд буюу нийт активын 40.68 хувийг эзлэж байна. Хэвийн зээлийн дүн өмнөх сартай харьцуулахад 0.51 хувиар өссөн бол өмнөх онтой харьцуулахад 6.68 хувиар өссөн байна.
- » Харин чанаргүй зээлийн хувь 9.14 хувь хүрч өмнөх сартай харьцуулахад -1.3 нэгж хувиар буурсан, өмнөх онтой харьцуулахад -0.9 нэгж хувиар буурсан байна.



- Ул уурхай, олборлолтын салбарын зээлийн үлдэгдэл
- Боловсруулах үйлдвэрлэлийн салбарын зээлийн үлдэгдэл
- Барилгын салбарын зээлийн үлдэгдэл
- Бөөний болон жижиглэн худалда, машин, мотоциклийн засвар, үйлчилгээний салбарын зээлийн үлдэгдэл
- Ул хөдлөх хөрөнгийн салбарын зээлийн үлдэгдэл
- Бусад

• Чанаргүй зээлийн хувь



Эх сурвалж: Монгол банк – Банкуудын нэгдсэн тайллан

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХҮҮ

Зээлийн хүү



Эх сурвалж: Монгол Банк-Сарын бюллутень

- Шинээр олгосон төгрөгийн зээлийн хүүгийн жигнэсэн дундаж нь 15.2 хувь хүрч өмнөх сартай харьцуулахад 0.3 нэгж хувиар өссөн бол өмнөх онтой харьцуулахад 2.1 нэгж хувиар өссөн байна.
- Харин шинээр олгосон валютын зээлийн хүүгийн жигнэсэн дундаж нь 10.2 хувь хүрч өмнөх сартай харьцуулахад -0.4 нэгж хувиар буурсан бол өмнөх онтой харьцуулахад 1.1 нэгж хувиар өссөн байна.

Хадгаламжийн хүү



Эх сурвалж: Монгол Банк-Сарын бюллутень

- Шинээр татсан валютын хадгаламжийн хүүгийн жигнэсэн дундаж нь 3.4 хувь хүрч өмнөх сартай харьцуулахад 0.9 нэгж хувиар өссөн бол өмнөх онтой харьцуулахад -0.2 нэгж хувиар буурсан байна.
- Харин шинээр татсан хадгаламжийн хүүгийн жигнэсэн дундаж нь 10.9 хувь хүрч өмнөх сартай харьцуулахад -0.1 нэгж хувиар буурсан бол өмнөх онтой харьцуулахад 5.2 нэгж хувиар өссөн байна.



АШИГТ АЖИЛЛАГАА


» 2022 оны 12 сарын 31-ны өдрийн байдлаар өөрийн хөрөнгө 4.5 их наяд хүрч өмнөх сартай харьцуулахад 7.93 хувиар өссөн бол өмнөх онтой харьцуулахад 30.01 хувиар өссөн байна.

» Тухайн оны ашиг, алдагдал 1.0 их наяд хүрч өмнөх сартай харьцуулахад 19.24 хувиар өссөн бол өмнөх онтой харьцуулахад 89.45 хувиар өссөн байна.


» 2022 оны 12 сарын 31-ны өдрийн байдлаар өөрийн хөрөнгийн өгөөж 23.06 хувь хүрч өмнөх сартай харьцуулахад 0.8 нэгж хувиар өссөн, өмнөх онтой харьцуулахад 7.2 нэгж хувиар өссөн байна.

» Нийт хөрөнгийн өгөөж 2.23 хувь хүрч өмнөх сартай харьцуулахад 0.0 нэгж хувиар өссөн, өмнөх онтой харьцуулахад 0.9 нэгж хувиар өссөн байна.

• Нийт хөрөнгийн өгөөж



• Өөрийн хөрөнгийн өгөөж



Эх сурвалж: Монгол банк – Банкуудын нэгдсэн тайллан




ИПОТЕКИЙН ЗЭЭЛ

- » 2022 оны 12 сарын 31-ны өдрийн байдлаар нийт ипотекийн зээлийн үлдэгдэл 6.5 их наяд хүрч өмнөх сартай харьцуулахад 1.73 хувиар өссөн бол өмнөх онтой харьцуулахад 14.74 хувиар өссөн байна. Нийт нийт ипотекийн зээлийн үлдэгдэлийн 0.81 хувийг ипотекийн хугацаа хэтэрсэн зээл, 0.22 хувийг ипотекийн хэвийн бус зээл тус тус эзлэж байна.
- » Ипотекийн хугацаа хэтэрсэн зээл өмнөх сартай харьцуулахад 6.94 хувиар өссөн бол өмнөх онтой харьцуулахад 119.66 хувиар өссөн байна.
- » Ипотекийн хэвийн бус зээл өмнөх сартай харьцуулахад 8.55 хувиар өссөн бол өмнөх онтой харьцуулахад -32.98 хувиар буурсан байна.

(их наяд төгрөг)

■ Ипотекийн зээлийн үлдэгдэл




108,633

Нийт зээлдэгчийн тоо
их наяд төгрөг

6.49

Нийт зээлийн үлдэгдэл




- 25-35 настай иргэд
- 35-45 настай иргэд
- 18-25 настай иргэд
- 45-55 настай иргэд
- 55-65 настай иргэд
- 65-с дээш

Эх сурвалж: Монгол банк – Банкуудын нэгдсэн тайлан

БОДЛОГЫН ХҮҮ

- » Төв банкнаас арилжаалж буй хамгийн богино хугацаатай үнэт цаасны хүүг бодлогын хүү гэнэ.
- » Монголбанкны бодлогын хүүний өсөлт мөнгөний хатуу бодлогыг илэрхийлэх бөгөөд инфляцын хөөрөгдлийг бууруулах, мөнгө, зээлийн агрегатуудын хурдацтай өсөлтийг сааруулж, зохистой төвшинд байлгах, эдийн засгийн хэт халалтаас сэргийлэхэд чиглэгддэг

• Бодлогын хүү



Эх сурвалж: Монгол банк – Банкуудын нэгдсэн тайлан

